

С И Т И С У Р Г У У Л И Й Н Н Э Г Ө Д Ö Р

2024 оны XII сар

77442244

info@citi.edu.mn

www.citi.edu.mn

CITI University

NEWS



“БИДНИЙ БАХАРХАЛ”

“ОЮУТНЫ ТАЛБАР”

“СУРВАЛЖЛАГА”

“CONGRATULATIONS”

“СИТИ СПОРТ”

“МАНАЙ БАГШ”

“НОМ ЯРЬЖ ӨГЬЕ”

“СИТИ NEWS”

“АМЖИЛТЫН ТҮҮХ”

“СУРВАЛЖЛАГА”

“БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН НЭГ ӨДӨР”



“СИТИ” Их сургуулийн Бизнесийн сургуулийн нэг өдрийг сурвалжлахдаа бид сургуулийн сургалт, орчин, оюутнуудын амьдрал, хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахаар зорьсон юм. Бизнесийн сургуулийн үүдийг нээж ороход, сургуулийн орчин тохилог, дулаан уур амьсгалтай, оюутнуудад таатай сэтгэл татахуйц орчин бүрдүүлсэн байх аж. Тав тухтай, орчин үеийн дизайнтай, цэвэр, эмх цэгцтэй анги танхим. Сургалтын мэдээллийн булан, танилцуулах самбаруудад оюутнууд болон сургуулийн үйл ажиллагаа,

хөтөлбөрүүд, олон улсын хамтын ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл харагдана. Бидний хажуугаар өнгөрөх оюутнууд эхний цагийн хичээлийн сэдвээ ямар сонирхолтой байсныг басхүү удахгүй оролцох тэмцээнийхээ бэлтгэл ажил хэрхэн өрнөж буйг хөөрөлдсөөр зөрлөө. Бидний сурвалжлах баг Бизнесийн сургуулийн захирал Г.Алтантовчийн өрөөг чиглэн алхлаа. Тэрээр биднийг угтаж, дөнгөж сая хичээл заагаад орж ирээд буйгаа хэлэв.

Төгсгөл нь II нүүрт >>

“МАНАЙ БАГШ”

Г.ГАНДИЙМАА: УЛСЫН БОЛОН ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭНД ОЮУТНУУДАА АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ БАЙГААГ ХАРААД БАХАРХДАГ

“СИТИ” Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн Гоо сайхны тэнхимийн эрхлэгч, Арьс, гоо заслын багш Г.Гандиймаатай ярилцлаа.

-Та “СИТИ” Их сургуулийг бакалавр болон магистр зэрэгтэй төгсч, одоо тус сургуульдаа багшаар ажиллаж байна. Энэ мэргэжлийг хэрхэн сонгох болсон бэ?

-Оюутан залуус, багш нар, уншигчдадаа энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд энэ салбарт 2007 хойш өдгөө 17 дах жилдээ ажиллаж байна. Гоо сайхны салбарт орох сонирхол бага наснаас минь л эхэлсэн. Ингээд 2011 онд анх ажлын байран дээр гарч байлаа. 2017 он хүртэл ажиллахдаа практикийн хувьд өөрийгөө чамлахааргүй л

хэмжээнд хүрчихэж байгаа юм. Мэдээж тэр хугацаанд мэдэхгүй зүйлстэй их тулгарсан л даа. Ингээд би онолын мэдлэггүйгээр цаашаа энэ мэргэжлээрээ ажиллахад хүндхэн юм байна гэх дүгнэлтэд хүрээд 2017 онд “СИТИ” Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн Гоо заслын урлаг, технологийн ангид элсэн суралцсан. Хамгийн анхны хичээл маань “Хоол, хүнс тэжээлийн судлал” байсан. Хичээл маань маш сонирхолтой санагдаж, мэргэжилдээ улам л дурлаж байлаа. Ингээд сургуулиа төгсөөд сургуульдаа багшаар ажиллах санал ирэхэд өөртөө эргэлзэж, өөрийгөө их голж байсан. Гэсэн хэдий ч багш хүн ямар байх ёстой вэ гэдгээс эхлээд дахин суралцаж, өөрийгөө хөгжүүлж өнөөдрийг хүрсэн байна.

Төгсгөл нь III нүүрт >>

“ОЮУТНЫ ТАЛБАР”

“СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус аа!

“СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус та бүхэнд өөрийн үзэл бодлоо олон нийтэд хүргэх, сэтгэн бодох, бичих ур чадвараа нээх гайхалтай боломжийг CITI CAMPUS NEWS олгож байна. Шинэлэг санал санаачилга, сонирхолтой мэдээ мэдээлэл, нийтлэлүүдээ бусдад хүргэхийг хүсч байвал бидэнтэй нэгдээрэй. “СИТИ” Их сургуулийн оюутан бүрт бидний үүд хаалга нээлттэй.

“СИТИ” ИХ СУРГУУЛИЙН УДИРДЛАГУУД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Ш.ЦОГТООГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАН, ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит эрдэм шинжилгээний “Шилдэг бүтээл” төрөлд “СИТИ” Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, профессор Ш.Цогтоо МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ: ЕРӨНХИЙ, ТУСГАЙ АНГИ” эрдэм шинжилгээний бүтээлээрээ I байр эзэлсэн билээ. Тэгвэл “СИТИ” Их сургуулийн удирдлагууд доктор, профессор Ш.Цогтоог хүлээн авч уулзан, хүндэтгэл үзүүлэн баяр хүргэж, дурсгалын зүйл гардууллаа. Энэ үеэр доктор, профессор Ш.Цогтоо хэлэхдээ, “СИТИ” Их сургуульдаа багшлаад жил гаруйн хугацаа өнгөрчээ. Хууль зүйн сургуулийн багш нартайгаа гар нийлэн хамтран ажиллаж байгаадаа тун баяртай байна. “СИТИ” Их сургууль оюутнуудын суралцах боломж нөхцөлийг бүрэн хангадгаас гадна мэдлэг, чадвартай доктор, профессор багш нарыг өргөн хүрээгээр ажиллуулдаг нь их зөв санагддаг хэмээн ярьсан юм. Мөн уулзалтын үеэр, “СИТИ” Их сургуулийн удирдлагуудад Хууль зүйн



сургуулийн багш, доктор, профессор Ш.Цогтоо “Монгол Улсын захиргааны

эрх зүй” номоо, Хууль зүйн сургуулийн багш, доктор Ц.Мөнх-

дэлгэр хууль зүйн докторын зэрэг хамгаалсан бүтээлээ дурсгалаа.



“СУРВАЛЖЛАГА”

“БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН НЭГ ӨДӨР”

» Түрүүч нь I нүүрт

Түүний ширээн дээр laptop-аас гадна CITI UNIVERSITY гэх логотой аяга, аяганы суурь, дэвтэр, үзэг гээд бүгд байх аж. Тэрээр бидний өмнө кофе аягалж зогсонгоо, манай сургууль зөвхөн дотоодын ААН, байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна, олон улсын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрүүд, оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Бид хамтын ажиллагаагаа улам тэлж, оюутнууддаа олон шинэ боломжийг бий болгоход анхаарч ажилладаг гэдгээ хэлэв.

Бизнесийн сургууль нь багшлах боловсон хүчиндээ ихээхэн анхаарч гадаад, дотоодын нэр хүндтэй сургуулиудад магистр болон докторын зэрэг хамгаалсан багш нараар бүрдүүлдэг. Бид үндсэн багш нарын зэрэгцээ эдийн засаг, бизнесийн салбарын шилдэг мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг байна.

“СИТИ” Их сургуулийн өвлийн элсэлт эхлэж буйтай холбогдуулан сургуулийнхаа хөтөлбөрүүдийг дурдсанаар бидний яриа үргэлжлэв. “СИТИ” Их сургуулийн Бизнесийн сургууль нь Бизнесийн удирдлагын тэнхим, Аялал жуулчлалын тэнхим гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй.

Бизнесийн сургууль нь:

- Менежмент
- Худалдаа
- Нягтлан бодох бүртгэл
- Маркетинг
- Аялал жуулчлал
- Зочлох үйлчилгээ
- Агаарын тээврийн үйлчилгээний мэргэжлээр бакалаврын,
- Бизнесийн удирдлага
- Хот бүс нутгийн менежмент
- Аялал жуулчлал
- Зочлох үйлчилгээ мэргэжлээр магистрын,
- Бизнесийн удирдлага
- Менежмент мэргэжлээр докторын хөтөлбөрөөр өвлийн элсэлт авч буйгаа тэрээр дуулгав.

Г.Алтановч захирал үргэлжлүүлэн, манай сургууль 50 гаруй төр, хувийн хэвшлийн олон байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж



бичиг байгуулан оюутан дадлагажуулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хамтарч хийх, төгсөгчдийг ажлын байраар хангах зэргээр хамтын ажиллагаанууд жил ирэх тусам чанаржин, өргөжиж байна. Оюутнуудад зөвхөн мэдлэг олгохоос гадна, тэдний ажлын байртай болох, мэргэжлээрээ амжилттай ажиллахын тулд хандлага, мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Бид оюутнууддаа зөв хандлага, чиг баримжаа олгож, ажлын байранд тэдний амжилттай оролцоог дэмжихэд анхаарч ажилладаг. Түүнчлэн манай сургуульд олон улсын оюутнууд суралцан бие биеэсээ соёл, зан заншил туршлагаа харилцан суралцдаг. Үүнийг дагаад олон үндэсний оюутнууд байгаа учир багш нартаа өндөр шаардлага тавьж гаднын оюутнуудад монгол хэл заахаас гадна хичээлүүдээ бүрэн англи хэл дээр явуулах тогтолцоо руу үе шаттай шилжиж байна. Түүнчлэн Бизнесийн удирдлагын чиглэлээр төгсөгчид сургуулиа төгсөхөөс өмнө ажлын байрны саналуудыг цөөнгүй авч

байгаа төдийгүй төгссөн хойно 90-100 хувийн ажлын байртай байгаа нь бид оюутнуудынхаа зөв хандлага, хөгжилд сайн анхаараад зогсохгүй цаашлаад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг сайн хийдэгтэй холбоотой гэж харж байна хэмээн ярьсан юм.

Энэ үеэр Бизнесийн сургуулийн III курсын оюутнууд “Худалдааны менежмент” хичээлийн хүрээнд танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик үйл ажиллагаатай холбон гүнзгийрүүлж, ажлын байранд дадлагажих, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай үр чадваруудыг эзэмшүүлэх зорилгоор “Скай хайпермаркет” ХХК-ийн “Имарт” сүлжээ дэлгүүртэй хамтран дадлага-семинарт хамрагдаад ирсэн байв. III курсийн оюутан Б.Намуун “Худалдааны менежмент” хичээлийнхээ хүрээнд практик дадлага хийгээд ирлээ. Багш нар маань бидэнд хичээлээ маш үр дүнтэй заадаг учраас практикт мэдэхгүй чадахгүй зүйл ховор байлаа. Ер нь манай сургууль хичээлээс гадна сургуулиас зохион

байгуулдаг дадлага, ажлын байрны санал, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтууд биднийг ихээхэн хэрэг болдог” гэсэн юм.

Бизнесийн сургууль нь Монгол анх удаа ХОТ, БҮС НУТГИЙН МЕНЕЖМЕНТ магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнийг Г.Алтановч захирал дурдав. Энэхүү эрэлттэй мэргэжлийг сонирхон ирж суралцах хүсэлтэй олон хүн байгааг тэрээр хэлж байв.

Танай хүүхдүүд зөв хандлагатай байдаг, танай төгсөгчдөөс ажилтан авмаар байна гэж ажил олгогчид ярьдаг. “СИТИ” Их сургуулийн төгсөгчид болон оюутнууд сургуулиа төгсөхөөс өмнө ажилд орж, амжилттай карьераа эхлүүлж байгаа нь сургалтын чанар, хамтын ажиллагааны үр дүнг батлан харуулж байна. Бизнесийн сургуулийн төгсөгчид ихэнх нь компани байгуулан ажиллаж, нээлтэндээ багш нараа урьж оролцуулдаг гэнэ. Түүнчлэн төрөлх сургуулиасаа оюутан авч ажиллуулдаг олон бизнес эрхлэгч төгсөгчид байдаг талаар Г.Алтановч захирал тодотгож байлаа.

**РЕДАКЦЫН ЗУРВАС**

Эрхэм оюутан залуус, багш ажилчид, уншигчдадаа шинэ жилийн мэнд дэвшүүлье! “СИТИ” Их сургуулийн “CITI CAMPUS NEWS” сонины хоёр дахь дугаарыг та бүхэнд өргөн барьж байна.

12 сар бол жилийн сүүлийн сар төдийгүй, ирэх шинэ оноо утгах, амжилт бүтээлээ эргэн харж дүгнэдэг сар билээ. 2024 он “СИТИ” Их сургууль болон багш, ажилчид, оюутнуудын хувьд амжилт, ололтоор дүүрэн нэгэн он байлаа. Энэ онд сургуулийн хамт олны хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүнд олон шинэ

амжилт, бүтээл төрөн гарч, сургалт, эрдэм шинжилгээний салбарт идэвхтэй оролцож, ажилласан жил байв. Багш нар зөвхөн мэдлэг олгохоос гадна, оюутнуудыг хүн болгон төлөвшүүлэх, мэргэжлийн үр чадварыг нь хөгжүүлэх, түүнчлэн нийгэмд эерэг хувь нэмэр оруулах шилдэг мэргэжилтэн болгон бэлтгэхэд анхаарч ажилласаар байна. Оюутнууд ч мөн өөрсдийн олж авсан мэдлэг, үр чадвараа бататгаж, улам хичээнгүйлэн суралцсаар байгаа билээ.

Дамшрамд дурдахад, “СИТИ” Их сургууль нь Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөр

2005, 2010, 2024 онуудад тус тус магадлан итгэмжлэгдлээ.

2024 оныг Багш, сургуулийн өмнөх боловсрол, Багш, гадаад хэлний боловсрол (англи хэл), Сувилахуй бакалаврын сургалтын хөтөлбөрүүдээ магадлан итгэмжлүүлсэн амжилттайгаар үдэж байна. Үргэлжлүүлэн бид бакалаврын 5 хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэхээр гэрээ хийн ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Энэхүү 12 дугаар сарын дугаартаа бид “СИТИ” Их сургуулийн “Бизнесийн сургуулийн нэг өдөр”-ийг сурвалжлан хүргэж, Гоо сайхны ухааны сургуулийн багш

Г.Гандиймаатай хийсэн ярилцлага, “СИТИ” Их сургуулийн төгсөгч, доктор Sang Yi (Сан И)-ийн ярилцлага, “СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан Э.Бямбасүрэн нарын ярилцлагыг онцоллоо. Түүнчлэн “СИТИ” Их сургуулийн багш, оюутнуудын амжилт болоод СИТИ “АЯНГА” волейболын шигшээ багаа байгуулсан зэрэг мэдээ мэдээллийг багтаалаа.

Та бүхэнд ирэх 2025 онд амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсье. Шинэ дугаараа шимтэн уншиж, шинэ мэдээлэлтэй танилцаарай.

“CITI CAMPUS NEWS” редакцын баг



“МАНАЙ БАГШ”

Г.ГАНДИЙМАА: УЛСЫН БОЛОН ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭНД ОЮУТНУУДАА АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ БАЙГААГ ХАРААД БАХАРХДАГ

» Түрүүч нь / нүүрт

Зарим хүмүүс гоо сайханч, гоо засалч гээд ярихаар амархан мэргэжил юм шиг яриад байдаг л даа. Угтаа би мэргэжлээ эмчтэй зүйрлэдэг байхгүй юу. Энэ мэргэжлийн нарийн мэдлэгийг сураад судлаад мэдэж ойлгоод ирэхээрээ мэргэжлээрээ бахархах сэтгэл төрдөг юм.

“СИТИ” Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн арьс, гоо заслын хөтөлбөрийн талаар яриач. Энэ хөтөлбөр ямар онцлогтой вэ?

-Үндсэндээ энэ салбарын технологи, цаг үе, амьдрах нөхцөл байдал, хүмүүсийн сэтгэхүй өөрчлөгдсөөр, салбарын судалгаа, шинжлэх ухаан хөгжин шинэчлэгдсээр байдаг. Нэн тэргүүнд хэлэх зүйл маань бол “СИТИ” Их сургууль Монголдоо анхдагч Гоо сайхны урлаг, технологиор бакалаврын зэрэг олгодог ганц сургууль гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Сургуулийн хөтөлбөр нь оюутнуудад зөвхөн онолын мэдлэг олгохоос гадна, практик ур чадвар эзэмшүүлэхэд чиглэгдсэн. Арьс, гоо заслын мэргэжил нь зөвхөн гоо сайхан гэхээсээ илүү хүний биеийн бүтэц, анатоми, сэтгэл зүйг танин мэдэх, цаашлаад харилцааны ур чадварыг заадаг. Бүхий л цогц мэдлэгийг олгоход чиглэдэг.

-Сургуулиас суралцсан мэдлэг, ур чадвар оюутнуудад хичээл заахад хэрхэн нөлөөлдөг вэ?

-Мэдээж, сургуулиас авсан мэдлэг, ур чадвар маань



Үндсэндээ энэ салбарын технологи, цаг үе, амьдрах нөхцөл байдал, хүмүүсийн сэтгэхүй өөрчлөгдсөөр, салбарын судалгаа, шинжлэх ухаан хөгжин шинэчлэгдсээр байдаг. Нэн тэргүүнд хэлэх зүйл маань бол “СИТИ” Их сургууль Монголдоо анхдагч Гоо сайхны урлаг, технологиор бакалаврын зэрэг олгодог ганц сургууль гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Сургуулийн хөтөлбөр нь оюутнуудад зөвхөн онолын мэдлэг олгохоос гадна, практик ур чадвар эзэмшүүлэхэд чиглэгдсэн.

оюутнуудад хичээл заахад маш том нөлөө үзүүлдэг. Бид маш сайн бэлтгэгдсэн мэргэжилтэнгүүд төгсгөхийг зорьдог. Мэргэжлийн өндөр түвшинд боловсорсон багш нараар удирдуулж, оюутнуудад шаардлагатай бүх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх нь сургуулийн гол зорилго юм.

-Та ямар арга барилаар оюутнуудад мэдлэг олгохыг илүүд үздэг вэ?

-Багшаар ажиллахдаа

оюутнуудад хамгийн түрүүнд бүх мэдээллийг зөвхөн заах бус, тэднээс асууж, хамтран ажиллахыг зорьдог. Оюутнуудад өөрсдийгөө үнэлэх, хувийн зорилгоо тодорхойлох, судалгаа хийж мэдлэг мэдээллээ өргөжүүлэх, өөрсдийгөө хөгжүүлэхэд нь анхаардаг. Манай оюутнууд улсын болон олон улсын тэмцээнд маш амжилттай оролцдог.

-Энэ мэргэжлээр суралцахыг хүсч байгаа залуучууд болон

сураглаж сургууль дээр их ирдэг л дээ. Тэд нартаа хандаж хэлэхэд та бүхнийг урьж байна, хүсэж зорьж байхад бүтнэ, болно гэж хэлье.

-Оюутан байх үедээ юуг сурахад хамгийн их цаг зарцуулж байсан талаараа яриач?

-Судалгаа шинжилгээ болоод багш нарын өгсөн бие даалтууддаа их цаг зарцуулдаг байсан. Энэ бүхний үр дүнд өөрийгөө дайчилж сурсан байдаг. **-БНСУ-ын Дэгү хотноо “WORLD K-BEAUTY FESTIVAL-2024” тэмцээнээс хос мөнгөн медаль хүртжээ. Ямар төрөлд хэрхэн амжилт үзүүлсэн талаараа хуваалцаач?**

-Би өнгөрсөн 10 дугаар сард БНСУ-ын Дэгү хотноо “WORLD K-BEAUTY FESTIVAL-2024” тэмцээн Face wax, Body wax, Sugaring wax, Eyebrow tattoo, Skin care, Body care, Nail art төрлөөр 12 дах удаагаа зохион байгуулагдсан тэмцээнд Face wax төрөлд мөнгөн медаль, Body wax-ийн soft wax ангилалд мөнгөн медаль мөн хүртсэн. Тэмцээнээсээ сурч мэдсэн зүйл олон бий. Мэдэхгүй зүйлсээ тэмцээний үеэр олж мэдэх ч зүйл бишгүй их. Сургуулиас маань тэмцээн уралдаанд оролцох, өөрийгөө сорих, хөгжүүлэх боломжийг цаг үргэлж олгож байдаг баярладаг.

Ц.ЦЭРЭНБЯМБА

“CITI CAMPUS NEWS” СОНИНЫ РЕДАКЦ

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

“СИТИ” Их сургууль

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.НОМИН-ЭРДЭНЭ

/“СИТИ” Их сургуулийн маркетингийн менежер/

СЭТГҮҮЛЧ:

Э.БЯМБАСҮРЭН

/“СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан/

Ц.ЦЭРЭНБЯМБА

/“СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан/

О.ЭНХСАРАН

/“СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан/

ХОЛБОО БАРИХ УТАС:

77442244

ЦАХИМ ХАЯГ:

Nomin-erdene.bazarragchaa@citi.edu.mn

ВЛИЙН ЭЛСЭЛТ ЭХЭЛЛЭЭ

“СИТИ” Их сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн өвлийн элсэлтийн бүртгэл эхэллээ. Та манай бүрэлдэхүүн сургуулиудад **Бакалавр, Магистр, Докторын** хөтөлбөрөөр элсэн суралцах боломжтой. Бүртгэл: **2024.12.02–2024.02.05-ныг** дуустал үргэлжилнэ. Та бүхэн **www.citi.edu.mn** болон “СИТИ” Их сургуулийн А байрны 201 тоотод биеэр ирж бүртгүүлэх боломжтой.

“БИДНИЙ БАХАРХАЛ”

Э.БЯМБАСҮРЭН: СЭТГҮҮЛ ЗҮЙГЭЭР СУРГАДАГ СУРГУУЛИУДЫГ СУДЛААД “СИТИ” ИХ СУРГУУЛИА СОНГОСОН

“СИТИ” Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан Э.Бямбасүрэн тэй ярилцлаа.

-Сэтгүүлч мэргэжлийг хэрхэн сонгон суралцах болсон бэ?

-Би багаасаа л бичих, унших сонирхолтой хүүхэд байсан болохор сэтгүүлч мэргэжлийг сонгоход илүү түлхэц болсон болов уу гэж бодож байна. Сэтгүүлчийн мэргэжлийн бусад мэргэжлээс ялгагдах гол онцлог нь надад өргөн хүрээг хамарсан санагддаг. Хэн хамгийн түрүүнд мэдээг олж, бусдад түгээж чаддаг вэ гэхээр сэтгүүлч л байдаг. Тиймээс цаг үеийн шаардлагад нийцүүлэн тухайн нөхцөл байдлыг цаг тухайд нь мэдээллэдэг, тэр цаг үеийн бодит дүр төрхийг харуулдаг мэргэжил гэдгээр нь сэтгүүлчийн мэргэжлийг сонгосон.

-“СИТИ” Их сургуулийг яагаад сонгон суралцав?

-Нэн тэргүүнд сургалтын орчин, хичээл орж буй багш нар, сургууль дотор зохиогддог арга хэмжээ, сургуулийн гадаад хамтын ажиллагаа болон хөтөлбөрүүдээ байнга шинэчилж, оюутнууддаа шинэ боломжуудыг эрэлхийлж, нээж өгдөг нь надад их таалагдсан. Тиймээс “СИТИ” Их сургуулийг сонгон суралцсан.

-Ямар сэдвээр бичих сонирхолтой вэ?

-Тухайн цаг үед ямар мэдээлэл нийгэмд хэрэгтэй байна, ямар

асуудлыг хөндөх хэргтэй байна тэр талаас нь бодож сэдвээ сонгодог. Миний хувьд эрэн сурвалжлах бүтээл болон нийтлэл, сурвалжлага бичих дуртай.

-Олон шагналын эзэн болсон байсан. Ямар ямар шагнал хүртсэн талаараа хуваалцаач?

-Отгонтэнгэр Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимээс сэтгүүлчээр сурдаг их, дээд сургуулиудын оюутнууын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Бид ертөнц” сэтгүүлзүйн шилдэг бүтээл шалгаруулах уралдаанд “Эх дэлхий бидний гэр” нийтлэлээрээ нийтлэлийн төрөлд шилдэг бүтээлээр шалгарч, Эргэлт.мн сайтад ажиллах эрхийн бичиг хүлээж авсан. Түүнчлэн Хүмүүнлэгийн ухааны их сургуулиас зохион байгуулдаг “Алтан үзэг” тэмцээнд “Өнөө оройн хоол өрийн дэвтэрт” сурвалжлагаараа “ШИЛДЭГ 20”-ын нэгээр шалгарч байсан. “Сэтгүүлч Батдорж” сангийн 11 дэх удаагийн оюутны сэтгүүл зүйн бүтээлийн 2 шаттай уралдаанд эхний шатанд амьдралын талаар эсээ бичиж, хоёр дах шатанд нь “Оюутны цагийн ажлын тухай” телевизийн богино нэвтрүүлэг хийж оролцон тусгай байр эзэлсэн. Энэ бүх тэмцээн уралдаанд сэтгүүлзүйн багш нар маань тусалж дэмждэгт маш их баярлалаа гэж хэлье.

-Хамгийн их үздэг медиа платформ тань юу вэ?



-Телевизүүдээс Eagle, NTV, Тэнгэр телевизийн мэдээллийн хөтөлбөрүүдийг үздэг. Сайтуудаас gogo.mn, ikon.mn, ergelt.mn, eguug.mn болоод сонинуудаас Өдрийн сонин, Зууны мэдээг уншдаг даа.

-Сэтгүүлчээр сурах сонирхолтой сурагчдад юу гэж хэлэх вэ?

-Сэтгүүлч мэргэжил судлаач байхыг шаарддаг мэргэжил. Тиймээс ном сайн уншдаг, судлаач байгаарай гэж хэлье. Аливаа зүйлийг бусдаас түрүүлж мэдэж бусдад мэдээллэх үүрэгтэй учраас сайн судалдаг байх хэрэгтэй. Хамгийн гол нь тухайн мэдээллээ үнэн зөв эсэхийг байнга шалгаж нотолж байх ёстой. Нэг

ёсондоо баримттай байх ёстой гэсэн үг. Чиний ярьж байгаа зүйл баримттай байх ёстой. Ярьж байгаа зүйлээ хэн ч уншсан ойлгох хэмжээнд бичих хэрэгтэй. Тиймээс бичгийн чадвар сайн байх хэрэгтэй. Бичгийн чадвараа сайжруулахын тул маш их зүйл унших хэрэгтэй. Б.Ринчен гуай “Ард түмэн сэтгүүлчийн үгээр ертөнцийг таньму.” гэж хэлсэн байдаг. Энэ үг хийх ёстой зүйлийг минь хэлж өгч байгаа юм шиг санагддаг. Нэмж хэлэхэд, сэтгүүлчээр суралцахыг хүсч байгаа бол “СИТИ” Их сургуулийг сонгон суралцаарай гэж хэлье.

О.ЭНХСАРАН

“ТӨГСӨГЧДИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ”

САН И: “СИТИ” ИХ СУРГУУЛЬ ГАДААД ОЮУТНУУДАД ЭЭЛТЭЙ, БАГШ НАР НЬ МАШ ТУСАРХАГ

“СИТИ” Их сургуулийн төгсөгч Sang Yi (Сан И)-тэй ярилцлаа.

-“СИТИ” Их сургуулийг урлаг судлалын докторын зэрэгтэй төгссөний дараа хаана амьдарч, ажиллаж байна вэ. Мэргэжлийн ажлаа үргэлжлүүлж байна уу?

-Тийм ээ, би мэргэжлийн ажлаа үргэлжлүүлэн, одоогоор өөрийн улсдаа Яньшанийн их сургуульд багшилж байна.

-Хэрхэн “СИТИ” Их сургуулийг сонгон суралцах болсон бэ?

-Миний магистрын ангийн найз надад “СИТИ” Их сургуулийг санал болгосон юм. Тэгээд л сургуулийнхаа талаар найзаасаа сонсоод шууд элсэж суралцахаар шийдсэн.

-“СИТИ” их сургуулиас олж авсан мэдлэг тань ажлын талбарт хэрхэн нөлөөлсөн бэ?

-Энд би гурван зүйлийг дурдах нь зүйтэй байх. Нэгдүгээрт, хэлний хувьд, нэг жил англи хэлээр харилцаж байсан нь миний амьдрал, ажил, эрдэм шинжилгээний салбарт англи хэлийг илүү чөлөөтэй ашиглах боломжийг олгож, соёлын ялгааг илүү хүлээн зөвшөөрөх, олон соёлыг холбож ойлгосон. Хоёрдугаарт, би урлаг, дизайны түүх, онолыг шинээр харах өнцгийг олж авсан. Монгол Улсад суралцаж байх хугацаанд зарим зүйл шинэ байсан бөгөөд ялангуяа орчин үеийн урлагийн мастерууд болон сонгодог



урлагийн онолуудын талаар өргөн мэдлэгтэй болж, Европын урлаг, дизайн сонирхолтой болсон. Гуравдугаарт, судалгааны арга зүй, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих чиглэлээр, миний докторын удирдагч Долгорсүрэн багш, Цэнгүүн багш надад илүү гүнзгий судалгаа хийх арга барил, бичих аргачлал, зарим нэг чухал ур чадварыг заасан. Энэ бүхэн миний эрдэм шинжилгээний ажилд ихээхэн хувь нэмэр болсон.

-“СИТИ” Их сургуульд сурч байх үеийн таны амьдрал ямар байсан бэ?

-2023 оны наймдугаар сарын 18-наас 2024 оны наймдугаар сарын 17 хүртэл би Улаанбаатар хотод нийт 365 хоног амьдарсан. “СИТИ” Их сургуульд суралцаж, Улаанбаатарт

бие даан амьдарсан маань надад хэзээ ч мартагдахгүй дурсамжийг үлдээсэн. Би өөрийнхөө шинэ ном болох “Нэг бүс, Нэг зам: Улаанбаатарын хотын орчин ба архитектурын соёл”-д бичсэнчлэн Монгол Улс бол гайхалтай улс. Энд ирж амьдарч, Монголын эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж, суралцсандаа маш их баяртай байгаа. Монголын график дизайн, хувцас загвар, хөгжим, бүжиг зэрэг нь маш их танигдсан. Түүнчлэн Сүхбаатарын талбайн сар бүрийн үйл ажиллагаа, Сөүлийн гудамж болон Улсын их дэлгүүрийн худалдааны төвүүд, жилийн хоёр удаагийн “автомашингүй өдөр”, наадам зэрэг надад Монголын хотын соёлын онцлогийг гайхалтайгаар мэдрүүлсэн. Хавар, намрын улиралд ууланд авирах, хот орчмын аялал хийх зэрэг нь байгаль дэлхийн үзэсгэлэнт сайхныг бүрэн утгаар нь ойлгоход тусалсан.

-“СИТИ” Их сургуулийн сургалтын арга барил танд хэрхэн санагдсан бэ?

-Багш нарын хичээл заах арга барил маш судалгаатай, өргөн хүрээтэй. Европ болон Азийн мэдлэг, туршлагыг хослуулан хуваалцдаг. Нөгөө талаасаа, “СИТИ” Их сургууль практик сургалтад маш их ач холбогдол өгдөг гэж би анзаарсан. Би сургуулийн архитектурын хичээлийн танхим болон хувцас

загварын ангиудаар зочлох үеэр оюутнуудын гар урлах чадвар ямар өндөр байгааг хараад уулга алдсан.

-Та багш нартайгаа одоо ч холбоотой байдаг уу?

-Тийм ээ, бид байнгын холбоотой байдаг. Багш нартаа эрүүл энх, сайн сайхныг үүгээр дамжуулан хүсэж байна.

-Монголд суралцах хугацаандаа ямар соёлын ялгаануудыг мэдэрсэн бэ. Эдгээрийг хэрхэн даван туулсан бэ?

-Миний хувьд дасан зохицох чадвар харьцангуй өндөр. Би хаана ч амьдарч, ажилласан тухайн газрын соёл, зан заншлыг хүндлэх ёстой гэж боддог. Монгол Улс бол Хятадтай удаан хугацааны түүхэн харилцаатай найрсаг хөрш орон. Монголд сурч, амьдрахдаа би ямар ч хүндрэлтэй зүйл мэдрээгүй. Харин ч би “СИТИ” Их сургуульд суралцаж, олон Монгол найз нөхөдтэй болохыг зөвлөх байна. “СИТИ” Их сургууль гадаад оюутнуудад ээлтэй, сургуулийн орчин тухтай, оюутнууд маш найрсаг, багш нар маань ч туслахдаа баяртай байдаг. Зарим оюутнууд англи хэлний ярианы чадваргүй, харилцаанаас санаа зовдог. Гэвч хэл бол зүгээр л хэрэгсэл учраас түүнийг ашиглаж сурах нь чухал гэж хэлмээр байна.

Э.БЯМБАСҮРЭН

“НОМ ЯРЬЖ ӨГЬЕ”

ДЭЛХИЙН ХАМГИЙН ШИЛДЭГ ЯРИХ ТЕХНИК



Бид энэ удаа Окамото жүнкогийн “Дэлхийн хамгийн шилдэг ярих техник” номыг онцолж байна. Ярианы ур чадвар гэдэг бүх цаг үед хамгийн чухал чадвар байсаар ирсэн. Учир нь бид ихэнхдээ бусдад өөрийгөө буруу эсвэл дулимаг ойлгуулснаас болж олон төрлийн асуудал урган гардаг. Хүмүүс бид өдөр тутамдаа харилцан ярилцаж байдаг ч ажлын талбарт ярианы ур чадвар маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэгвэл энэхүү ном нь санаагаа бүрэн ойлгуулах, зөв загнаж, зөв магтах, бусдыг өөртөө татах, харизмтай

илтгэх зэрэг олон төрлийн ярианы ур чадварыг эзэмшиж өөрийгөө бусдад зөв илэрхийлэх, бусдыг удирдах чадварт суралцан ажил, амьдралдаа эерэг өөрчөлт гаргах боломжыг олгосон бүтээл юм. Өдөр тутмын эгэл ярианаас илтгэх урлаг хүртэлх бүхий л харилцан ярианы алтан 50 дүрмийг багтаасан бүтээлийг багш, ажилчид, оюутан залуус та бүхнийг уншихыг санал

болгож байна. Энгийн яриа асуух үгийн хүчээр илүү сайн болно. Харилцан ярианд хэн олон асуулт тавьсан нь ярилцаж буй нөгөө талаа сайн мэдэж чаддаг бөгөөд дахин уулзах магадлал өндөр байдаг гэсэн Харвардын Бизнесийн сургуулийн судалгаа ч бий. Тэгвэл хэрхэн сайн асуулт тавих вэ? “Юу гэж бодож байна вэ?” “Юунд дуртай вэ?”

“Яамаар байна вэ?”
 “Аль нутгийнх вэ?”
 “Ямаршуухан байна вэ?”
 “Яавал?”
 Ямар ч хүн дээрх зургаан асуултыг тогтоогоод авсан байхад 5-10 минутын харилцан яриаг төвөггүй өрнүүлж чадна.

НОМЫН САНЧ, МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН Б.САЙНТУЛГА

“СИТИ” Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан Ц.Цэрэнбямбын “ОРШИХУЙ” шүлгийг та бүхэнд толилуулж байна.

ОРШИХУЙ

Үрийн тэнгэр эцгийн минь гэрийг мялааж
 Үйлийн үрийг эмээ минь эрх тарнидаа зангидаж
 Хурайлсан их дээдсийн онгон тулганы өмнө сөхөрч
 Хувь заяаны айдсыг эцэг минь үнэг хайчилж домносон
 Шар нарны орон зайд хүний орчлонд мэндлэхдээ
 Шагай шиг дөрвөн цагт хүй нь болж төрсөн
 Шүдгүй ам ангалзуулж тэнгэр сарвайж уйлахдаа
 Шүхэрт энэ орчлонгийн хүн болж буй оршихуй
 Хөөргөж бүсэлсэн дээлийн өвөрт үнэгчилж тавтай нойрссон
 Хөөмийн эгшгийг бүүвэйн дуутай сонсож хэлд орсон
 Хөдсөн бойтог Дэлхийн зулайтай ноцолдуулж хөлд орсон
 Хөөргөний толгой шиг балчир насны минь эхлэл энд оршихуй
 Үлгэр хүүрнэсэн өвгөдийн өлчир үгэнд эрхэлж
 Үлэмжийн чанарын айзамд уярч ухаарч өссөн
 Үнэн худлын босгонд сөгдөж босож явсан
 Үүрд орших заяа минь тэнгэрлэг оршихуй
 Алагдсан дайсан шиг зэвхий энэ орчлонгийн
 Аясын салхинд намирч замбуулинг туулж явахдаа
 Адуутай цуг харийн нутгаас хавар цагт гүйсэн юм шиг
 Алтан бумба сэтгэл минь эгнэгт оршихуй
 Дуут шувуудын өндгийг гарынхаа алганд няцалж
 Дурамжхан зэмлэх эх орондоо нүглээр хахаж явснаа
 Дуртгал эргэх насны өнгө нэмэхийн цагт
 Дулимхан унагасан нулимс минь ухаарал оршихуй
 Орсон буур шиг цаг хугацааны хаанчлал цалмаас
 Ороо морь шиг цаглах мөрөөдлийн хаяа руу хулжихад
 Бурхан чөтгөрийн гэсгээлт тэнгэр аргадаж амьдрахдаа
 Буруу зөвийн дэнсэнд минь үйлийн үр оршихуй
 Би оршихуй



"CITI NEWS"

ЭРАСМУС+ АЗИ, НОМХОН ДАЛАЙ, ОЙРХИ ДОРНОДЫН БҮСИЙН УУЛЗАЛТАД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ



Европын Холбооноос зохион байгуулсан "Цахим шилжилт" сэдэвт Эрасмус+ Ази, Номхон Далай, Ойрхи Дорнодын бүсийн уулзалт 2024 оны 11 дүгээр сарын 13-14-нд Тайланд Улсын нийслэл Бангкок хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү уулзалтад "СИТИ" Их сургуулийн Ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа, Гадаад харилцааны албаны дарга Т.Алтанцэцэг, Сургалт эрхэлсэн захирал Г.Жаргалмаа нар оролцлоо. Гадаад харилцааны албаны дарга Т.Алтанцэцэг Монгол, Вьетнамын их, дээд сургуулиудад хэрэгжиж

буй DIGITAL MOVE төслийн талаар илтгэл тавьж, олон улсад цахим шилжилтийг эрчимжүүлэх талаар санал солилцлоо. Мөн Эрасмус+ төсөл хэрэгжүүлэгч их, дээд сургуулиуд, дэмжигч байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг эхлүүлэхээр боллоо. Европын Холбооноос хэрэгжүүлж буй DIGITAL MOVE төсөлд Франц, Словак, Вьетнам, Монгол Улсын 12 их, дээд сургууль оролцож байгаа бөгөөд "СИТИ" Их сургууль зохицуулагч байгууллагаар ажиллаж байна.

ТАЙЛАНД УЛСЫН ЧУЛАЛОНГКОРНЫ ИХ СУРГУУЛЬД ЗОЧЛОВ



"СИТИ" Их сургуулийн Ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа, Гадаад харилцааны албаны дарга Т. Алтанцэцэг Ph.D, Сургалт эрхэлсэн захирал Г.Жаргалмаа Ph.D нар 2024 оны 11 дүгээр сарын 13-нд Чулалонгорны их сургуулийн Integrated Innovation сургуульд зочиллоо. Төлөөлөгчдийг тус сургуулийн дэд захирал Пиетро

Борсано хүлээн авч, хоёр их сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцлоо. Чулалонгорны их сургууль Asia for Global Impact THE Impact зэрэглэлд 1, Тайландын их дээд сургуулийн зэрэглэлд 1, дэлхийн шилдэг 100 сургуульд багтдаг дээд боловсролын байгууллага юм.

ТАЙЛАНДЫН ПАНИАПИВАТЫН МЕНЕЖМЕНТИЙН ДЭЭД СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



"СИТИ" Их сургуулийн Ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа, Гадаад харилцааны албаны дарга Т.Алтанцэцэг, Сургалт эрхэлсэн захирал Г.Жаргалмаа болон Тайландын Хант Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны 1 дүгээр нарийн бичгийн дарга Б.Галданжамц нар 2024 оны 11 дүгээр сарын 14-нд Паниапиватын Менежментийн дээд сургуульд зочиллоо. Төлөөлөгчдийг тус сургуулийн ерөнхийлөгч Сомпоп Манарунгсан, Олон улсын маркетинг, ажилтан сонгон шалгаруулах албаны дарга Танарат Теератанакиат, Гадаад харилцааны албаны дэд

дарга Панжапорн Лаухапутра нар халуун дотноор хүлээн авч, хоёр их сургуулийн хоорондын хамтын ажиллагааг эхлүүлэх, тодорхой чиглэлээр хөгжүүлэх талаар санал бодлоо солилцлоо. Төлөөлөгчид тус сургуулийн агаарын тээвэр, зочлох үйлчилгээний сургалтын баазтай танилцав. Тайланд, Монгол хоёр улсын дээд боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжин ажиллаж буй Тайландын Хант Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны хамт олонд талархал илэрхийлье.

АРХИТЕКТУР-ДИЗАЙНЫ СУРГУУЛИЙНХАН ДЭЛХИЙН АРХИТЕКТОРУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО



2024 оны 11 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Малайз улсын Куала-Лумпур хотод Дэлхийн архитектур-дизайны чуулга уулзалт зохион байгуулагдлаа. Энэхүү чуулга уулзалтад 5 тивийн 100 гаруй улс орон оролцож, олон улсын архитектурын чиг хандлага, шинэ санал, санаачлагуудыг хэлэлцсэн юм. Монгол Улсаас тус чуулга уулзалтад "СИТИ" Их сургуулийн Архитектур, дизайны сургуулийн захирал Э.Шинэзаяа, багш А.Намуун нар оролцлоо. Чуулга уулзалтад 800 гаруй эрдэм шинжилгээний ажил ирснээс 120 судалгааны ажил шалгарч, Монгол Улс "Социализмын үеийн монгол

дахь барилгуудад хэрэглэсэн чимэглэлийн элементийн хөгжлийн судалгаа" сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлээ танилцууллаа. Судалгааны ажлыг Э.Шинэзаяа, А.Намуун, Б.Байгал-Эрдэнэ, Мохд Азли Мохамед Жамил нар хамтран бичиж, Монгол болон Малайз улсын хамтарсан судалгааны ажил болсон юм. Мөн чуулга уулзалтаар гурван жилд нэг удаа зохиогддог UJA (Дэлхийн Архитекторуудын Нэгдсэн Холбоо) Ерөнхий Ассамблей зохион байгуулагдлаа. Монгол Улс хоёр саналын эрхтэйгээр оролцож, 13 зүйл заалтын өөрчлөлт дээр санал өгөв.

"CITI NEWS"

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ОДОНГЭРЭЛ "AIR SILK ROAD" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ФОРУМД ОРОЛЦЛОО



"СИТИ" Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор, дэд профессор Б.Одонгэрэл БНХАУ-ын Нанжин хотод зохион байгуулагдсан "Air Silk Road" сэдэвт олон улсын форумд оролцлоо. Тус хурал нь БНХАУ, Монгол, Кени, Непал, Камбож зэрэг улс орнуудын их, дээд сургуулийн захирал болон боловсролын салбарын ажилтнуудын оролцоотой зохион байгуулагдсан бөгөөд энэ үеэр

оролцогчид ирээдүйн эрдэмтдийн олон улсын чадамж, боловсролын солилцоо, хамтын ажиллагаа, соёлын нөлөө зэрэг олон чухал сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Хурлын үр дүнд "СИТИ" Их сургууль зарим улс орны их, дээд сургуулийн удирдлагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх, оюутан, багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр санал солилцов.

"СИТИ" ИХ СУРГУУЛЬ "АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОВСРОЛ, ХӨГЖЛИЙН НИЙГЭМЛЭГ" НҮТББ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАВ



"СИТИ" Их сургуулийн Бизнесийн сургуулийн захирал Г.Алтантовч, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Д.Батболд нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү хамтын ажиллагаа нь аялал жуулчлалын боловсрол,

зочлох үйлчилгээний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, инноваци, эрдэм шинжилгээний ажилд хамтран оролцох, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, дадлагажуулах, сургалт, судалгаа хийх зэрэг олон чиглэлд хамтран ажиллах зорилготой юм.

ОРЧУУЛАГЧИЙН АНГИЙН ОЮУТНУУД ОРЧУУЛГЫН ХЭЭРИЙН ДАДЛАГАД ГАРАВ



"СИТИ" Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн "Солонгос хэлний орчуулагч"-ийн III курсийн оюутнууд, зөвлөх багш Ч.Батчимэгийн хамт 11-р сарын 8-9-ний өдрүүдэд орчуулгын хээрийн дадлагаар Өвөрхангай, Архангай аймгийн түүх, соёлын дурсгалт газруудаар аяллаа. Аяллын хүрээнд гадаад, дотоодын жуулчдын зорин очдог Элсэн тасархай, Эрдэнэзуу зэрэг

байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлтой танилцсан юм. Оюутнууд тухайн аймгуудын түүх, соёлын өвийн талаарх мэдээллийг жуулчдад хүргэж, орчуулгын ур чадвараа ахиуллаа. Энэхүү орчуулгын хээрийн дадлага нь онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх, туршлага хуримтлуулах, ур чадвараа хөгжүүлэх чухал ач холбогдолтой юм.

"ЧИХРИЙН ШИЖИНТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР"



2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг дэлхий даяар "Чихрийн шижин ба Сайн сайхан байдал" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэ өдрийг тохиолдуулан "СИТИ" Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн Сувилахуйн тэнхим, CITI NURSING клубээс "СИТИ" Их сургуулийн багш, оюутнуудад чихрийн шижин өвчний тархалт, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгөх өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр Гоо сайхны ухааны сургуулийн багш Л.Алтанхуяг "Чихрийн шижин өвчний тархалт, илрэх шинж тэмдэг, эмчилгээ", СУ-ны магистр, багш Н.Мөнгөнсор "Чихрийн шижин өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ", АУ-ны магистр, багш Г.Гантөгс нь "Чихрийн шижин өвчний үед хэрэглэх болон хориглох хоол хүнс" болон "Чихрийн шижингийн арьсны хүндрэлийн үед гоо сайхны арчилгаа" сэдвээр илтгэл тавьж, олон чухал зөвлөмжийг өгөв.



"CITI NEWS"

"СИТИ" ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧИД МОГЖООХОН ЦЭЦЭРЛЭГТ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БЭЛЭГЛЭВ



"СИТИ" Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Багш, сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчид нийгмийн хариуцлагын хүрээнд

"СИТИ" Их сургуулийн дэргэдэх Могжоохон цэцэрлэгийн бяцхан дүү нартаа сургалтын хэрэглэгдэхүүн бэлэглэлээ.

ДЭЛХИЙН "ДОХ"-ТОЙ ТЭМЦЭХ ӨДӨР



"СИТИ" Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн Сувилахуйн тэнхимээс "ДОХ"-той тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлээ. Тэгвэл өдөрлөгийн эхэнд Сувилахуйн тэнхимийн эрхлэгч Г.Бор "ХДВХ, ДОХ-Өвчний тархалт, өнөөгийн байдал" сэдэвт лекц тавьж, ХДХВ-ийн тархалт, нийгмийн болон эрүүл мэндийн эрсдэлүүд, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Түүнчлэн, СБДЭМТ-ийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын кабинетын

зохицуулагч Б.Одцэцэг "Бэлгийн замаар дамжих халдварт өвчнүүд" сэдэвт лекц уншиж, халдварт өвчнүүдийн тархалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлгийн боловсролын ач холбогдлыг онцлон яриу. Өдөрлөгийн үеэр "ХДХВ-ДОХ"-с урьдчилан сэргийлэх талаар гүнзгий мэдээлэл өгч, оюутнуудтай санал солилцон, эрүүл мэндийн үзлэг, витамин, бэлгэвч тараах зэрэг үйл ажиллагаа явууллаа.

"ҮДШИЙН ГОЁЛ 2024" УРАЛДААН ЗАРЛАГДЛАА

EVENING GOWN 2024

ГОЁЛЫН
ХУВЦАСНЫ
УРАЛДААН


Зорилго: 2024-2025 оны даашинзны загварын шинэ чиг хандлага түгээн танилцуулах.

Хамрах хүрээ: 1-4-р курсийн бүх оюутнууд оролцох боломжтой.

Хэрхэн оролцох вэ: Оюутан тус бүр эрэгтэй, эмэгтэй аль ч төрлийн гоёлын хувцас урлаж үзүүлбэрт оролцоно.

Шагнал:

I байр, талархал, мөнгөн шагнал
II байр, талархал, мөнгөн шагнал
III байр, талархал, мөнгөн шагнал



I шат: 2024 оны 12-р сарын 6-нд мэргэжлийн багш нарын үнэлгээ /Тренд, шинэлэг байдал, эскиз зураг, эсгүүр, оёдлын технологи/

II шат: 2024 оны 12-р сарын 11-нд тайз загварын үзүүлбэр /Модел, нүүр будалт, имидж, аксессуар чимэглэл/

АМЖИЛТ ХҮСЬЕ!

"СИТИ" Их сургуулийн Архитектур-Дизайны сургуулийн Хувцас дизайны тэнхимээс Хувцас дизайны I-IV курсийн оюутнуудын дунд "Evening Gown-2024" гоёлын даашинзны уралдаан зарлалаа. Энэхүү уралдаан нь оюутнуудын мэргэжлийн ур чадварыг өөрсдийн бүтээлээр илэрхийлэн танилцуулах, шинэ оныг угтан гоёлын даашинзны шинэ урсгал, загварын чиг хандлагыг түгээх зорилготой юм.

БОЛЗОЛ:

Уралдаанд оролцогч бүр эрэгтэй, эмэгтэй аль ч төрлийн 1 буюу түүнээс дээш гоёлын хувцас урлаж, үзүүлбэрт оролцоно.

ШАЛГАРУУЛАЛТ:

Эхний шалгаруулалт:

2024 оны 12-р сарын 6-нд мэргэжлийн багш нарын үнэлгээний дагуу шалгаруулалт явагдана. Шалгаруулалтын явцад тренд чиг хандлага, шинэлэг байдал, сэдлийн самбар, эскиз зураг, зохион бүтээлт, технологи зэрэг үзүүлэлтүүдээр тус тус үнэлэгдэнэ.

Эцсийн шалгаруулалт:


2024 оны 12-р сарын 11-нд загварын үзүүлбэрийн үеэр модел нүүр будалт, имидж бүрдүүлэлт, аксессуар чимэглэл зэрэг үнэлгээний шалгуур болно.

ШАГНАЛ:

I байр: Талархал, мөнгөн шагнал
II байр: Талархал, мөнгөн шагнал
III байр: Талархал, мөнгөн шагнал

"CITI NEWS"


"ТАМЫН ДУРЛАЛ" ЭКСПЕРИМЕНТАЛ ЖҮЖИГ ТОГЛОНО



"СИТИ" Их сургуулийн Урлагийн сургуулийн Жүжиглэх, Найруулах урлагийн тэнхимийн IV курсийн оюутнуудын тайзны бүтээл болох Нобелийн шагналт зохиолч Южин О'Нилын "Тамын Дурлал"

экспериментал жүжиг 12 дугаар сарын 09-нд 17:00 цагаас "СИТИ" Их сургуулийн хичээлийн Б байранд тоглогдоно. Та бүхнийг өргөнөөр хүрэлцэн ирэхийг урьж байна.

"ОРЧИН ҮЕИЙН БОЛОВСРОЛЫН ЧИГ ХАНДЛАГА БА ИДЭВХТЭЙ СУРГАЛТЫН ХЭЛБЭР"



"СИТИ" Их сургуулийн Бизнесийн сургуулийн багш, доктор Ч.Энхболд багш нарт зориулан "Орчин үеийн боловсролын чиг хандлага ба идэвхтэй сургалтын хэлбэр" сэдвээр илтгэл тавилаа. Түүний илтгэлд орчин үеийн сургалтын арга барил нь багшаас технологийн мэдлэг, суралцагчдын хэрэгцээнд нийцсэн агуулга боловсруулах, харилцаа, бүтээлч ур чадварыг хөгжүүлэх өндөр түвшний ур чадварыг шаардахыг онцлон тэмдэглэж, энэ нь багшийг уламжлалт мэдлэг

түгээгчийн үүргээс илүүтэйгээр суралцагчийн хөгжлийг дэмжигч, чиглүүлэгч байхыг шаардаж байгааг онцлов. Түүнчлэн орчин үеийн сургалтын арга барил нь суралцагч төвтэй, технологи ашигласан, практик туршлагад суурилсан, уян хатан байдлаараа онцлог бөгөөд энэ нь суралцагчдыг ирээдүйн хөдөлмөрийн зах зээлд илүү өрсөлдөх чадвартай, бүтээлч, нийгмийн хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдэж байгааг мөн тодотголоо.


"СИТИ" ИХ СУРГУУЛЬ "АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА-2024" ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



"СИТИ" Их сургууль "АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА-2024" эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгууллаа. Уг хурал нь аялал жуулчлалын салбарын хэмжээнд хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг олон нийтэд таниулах, түгээн дэлгэрүүлэх, судалгааны нэгдсэн мэдээллийн сан үүсгэх,

аялал жуулчлал судлалыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг билээ. Тус эрдэм шинжилгээний хурлаар Бизнесийн сургуулийн багш нар "Дотоодын аялал жуулчлалын зорих газрын дүр төрхийн судалгаа: Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн жишээн дээр" сэдэвт илтгэлээ хэлэлцүүлээ.

АРХИТЕКТУР-ДИЗАЙНЫ СУРГУУЛЬ "САКСИД" ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



"СИТИ" Их сургуулийн Архитектур-Дизайны сургуулийн захирал Э.Шинэзаяа "САКСИД" ХХК-ийн ерөнхий захирал Н.Ганзориг нар хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд оюутан суралцагсдад зориулсан загвар дизайны

уралдаан, тэмцээн, үзэсгэлэн худалдаа, мэргэжлийн чиглэлээр хамтран сайн үйлсийн аян зохион байгуулах, ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй дотоод болон гадаад байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр болов.



"CONGRATULATIONS"

ОЛОН УЛСЫН WEB OF SCIENCE БОЛОН SCOPUS САНД БҮРТГЭЛТЭЙ СЭТГҮҮЛҮҮДЭД ӨГҮҮЛЭЛ БИЧСЭН БАГШ НАРТ ШАГНАЛ ГАРДУУЛАВ



"СИТИ" Их сургууль "ШИНЖЛЭХ УХААНЫ АЖИЛТНЫ ӨДӨР"-ийг 11 дүгээр сарын 27-нд тэмдэглэн өнгөрүүлээ. Энэхүү арга хэмжээгээр өнгөрсөн 1 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хийсэн ажлууд болон гарсан үр дүнг танилцуулсан юм. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд "СИТИ" Их сургуулийн эрхлэн гаргадаг CITI SCIENCE сэтгүүлийг олон улсын

бүртгэлийн crossref.org сайтанд бүртгүүлж, онлайн бүртгэлийн DOI дугаартай болсноор шинжлэх ухаан, судалгааны олон улсын тавцанд гаргасан томоохон алхам болсон юм. Түүнчлэн, Монголын их, дээд сургуулиудын үндэсний эрэмбэ, чансаагаар 11 байр, эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтээр 8 байрт эрэмбэлэгдсэн амжилттайгаар сургуулийнхаа

нэр хүндийг олон улсын түвшинд ахиуллаа. Мөн хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг Кембриж Монголын хоёр дахь удаагийн форум 2024 онд Улаанбаатар хотноо "Дэлхийн асуудал, нүүдэлчдийн шийдэл" сэдвийн дор амжилттай зохион байгуулагдсан бөгөөд "СИТИ" Их сургууль хамтран зохион байгуулагчаар оролцож, үндсэн илтгэлийг тавьсан юм. Арга

хэмжээний үеэр, Web of Science болон Scopus санд бүртгэлтэй сэтгүүлүүдэд 1 жилийн хугацаанд 5 өгүүлэл бичиж, эрдэм шинжилгээний салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан "СИТИ" Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, академич Ж.Тэмүүжинд "СИТИ" Их сургуулийн Ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа шагнал гардууллаа.

"МОНГОЛЫН ҮСЧИН, ГОО ЗАСАЛЧ, ХУМС УРЛААЧДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 2024" ТЭМЦЭЭНД "СИТИ" ИХ СУРГУУЛЬ ШИЛДЭГ СУРГУУЛЬ БОЛЛОО



Энэхүү тэмцээнд Гоо сайхны ухааны сургуулийн:

- Арьс, гоо заслын багш Г.Гандиймаа,
- Нүүр хувиргалтын ахлах багш Г.Хос-Эрдэнэ,
- Make-up-н багш Л.Маралмаа,
- Nail art-н багш О.Чинзориг,
- Үсчин стилистийн багш Э.Уянга, Н.Ирмүүн нар оюутнуудаа

удирдан амжилттай оролцлоо.

МАСТЕР АНГИЛАЛ

"Хуримын үс засалт" төрөлд:

IV байр Үсчин стилистийн багш Н.Ирмүүн

"Эмэгтэй урт үсний долгион" төрөлд:

II байр Үсчин стилистийн багш Н.Ирмүүн

ОЮУТНУУДЫН АМЖИЛТ

"Creative Color" төрөлд:

IV байр Арьс, гоо заслын III курсийн оюутан Г.Мөнхшүр

"Сормуусны хими" төрөлд:

IV байр Арьс, гоо заслын III курсийн оюутан А.Урантогос

"Үдшийн будалт" төрөлд:

II байр Арьс, гоо заслын II курсийн оюутан Т.Ариунтунгалаг

III байр Арьс, гоо заслын II курсийн оюутан Б.Амарзаяа

IV байр Арьс, гоо заслын III курсийн оюутан Б.Сарантуяа

V байр Арьс, гоо заслын III курсийн оюутан О.Халиун

"Салон Фрэнч" төрөлд:

II байр Арьс, гоо заслын I курсийн оюутан Т.Цэрэндолгор

III байр Арьс, гоо заслын III курсийн оюутан Н.Мөнгөншагай

IV байр Арьс, гоо заслын III курсийн оюутан О.Хулан

"Салон маникюр" төрөлд:

II байр Арьс, гоо заслын I курсийн оюутан Т.Цэрэндолгор

"Эмэгтэй үсний бэлэн бүтээл" төрөлд:

III байр Арьс, гоо заслын III курсийн оюутан О.Хулан нар тус тус шалгарлаа.

ОЮУТАН Б.БАТХҮҮ "УРАН УНШЛАГА" ТӨРӨЛД I БАЙР ЭЗЭЛЛЭЭ



Үндэсний номын сангаас зохион байгуулсан Орчин цагийн уран зохиолыг үндэслэгч С.Буяннэмэхийн зохиол бүтээлийг таниулах, сурталчлах "УНШЛАГЫН 7 ХОНОГ" арга хэмжээнд "СИТИ" Их сургуулийн оюутнууд амжилттай оролцлоо. Энэхүү арга хэмжээний "УРАН УНШЛАГА" төрөлд "СИТИ" Их сургуулийн Урлагийн сургуулийн Жүжиглэх, найруулах урлагийн I курсийн оюутан Б.Батхүү I байр эзэллээ.

“CONGRATULATIONS”

ОЮУТАН Д.ОЮУНЦЭРЭН ГРАНПРИ ХҮРТЭВ



“Үндэсний улсын аварга шалгаруулах үсчин, гоо сайхан, хумс, дизайн урлалын XXVI их наадам”-д “СИТИ” Их сургуулийн багш, оюутнууд амжилттай оролцож, “ГРАНПРИ” хүртлээ. Тус тэмцээнд Гоо сайхны ухааны сургуулийн Нүүр хувиргалтын ахлах багш Г.Хос-Эрдэнэ оюутнуудаа удирдан оролцож, дараах төрлүүдэд шагналт байр эзлэв.

“ТАЙЗНЫ НҮҮР БУДАЛТ”

I байр: Д.Оюунцэрэн (Арьс, гоо заслын IV курс)
II байр: Ж.Мягмарцэцэг (Үсчин, стилистийн II курс)
III байр: Т.Ариунтунгалаг (Арьс, гоо заслын II курс)
IV байр: И.Номин (Арьс, гоо заслын IV курс)
“ХУРИМЫН НҮҮР БУДАЛТ”

I байр: Г.Бадамхорлоо (Үсчин, стилистийн II курс)
IV байр: Н.Анужин (Арьс, гоо заслын IV курс)
“BODY ART”
I байр: Д.Оюунцэрэн (Арьс, гоо заслын IV курс)
II байр: О.Номин-Эрдэнэ (Үсчин, стилистийн II курс)
III байр: И.Номин (Арьс, гоо заслын IV

курс)
IV байр: О.Номинжин (Үсчин, стилистийн II курс) тус тус эзэллээ.
“ШИЛДЭГ ЭМЭГТЭЙ МОДЕЛ”
 Арьс, гоо заслын III курсийн оюутан Б.Сарантуяа
 Ийнхүү хоёр ажилбартай төрлийн нийт оноогоор Арьс, гоо заслын IV курсийн оюутан Д.Оюунцэрэн “ГРАНПРИ” шагналын эзэн боллоо.

“АРЬС ШИРЭН ЭДЛЭЛ-2025” ЗАГВАРЫН УРАЛДААНЫ ЯЛАГЧИД ТОДОРЛОО



“СИТИ” Их сургуулийн Архитектур-Дизайны сургууль “Уушгийн Агуй” ХХК-тай хамтран “Хувцас дизайн”-ы I-IV курсийн оюутнуудын дунд зохион байгуулсан “Арьс ширэн эдлэл-2025” загвар дизайн, эскизийн уралдаан амжилттай болж өнгөрлөө. Энэхүү уралдаан нь Монголын дизайн урлагийг хөгжүүлэх, шилдэг оюутан дизайнеруудыг алдаршуулах, тэдний

бүтээлийг сурталчлах, хөхүүлэн дэмжих, хамтран ажиллах зорилгоор зохион байгуулагдсан билээ. Энэхүү уралдааны ерөнхий ивээн тэтгэгчээр “Уушгийн агуй” ХХК, “Саксид” ХХК-ийн “Faber-Castell”, “Posca”, “Monte Mart” брэнд хамтран ажиллалаа. Энэ үеэр Архитектур-Дизайны сургуулийн захирал Э.Шинэзаяа “Уушгийн Агуй” ХХК-ийн ерөнхий захирал М.Гансүх

нар хамтран ажиллах санамж бичиг байгуулав.
 “Арьс ширэн эдлэл-2025” загвар дизайн, эскизийн уралдаанд дараах оюутнууд шагналт байранд шалгарав.
 IV курсийн оюутан М.Отгонзул, Э.Мөнхтулга, Х.Нандин-Эрдэнэ, Э.Ууганзаяа
 III курсийн оюутан Г.Сүнжидмаа

II курсийн оюутан Г.Ганчимэг нарыг “Уушгийн Агуй” ХХК-наас “Богц”, “Хүннү” брэндийн бүтээгдэхүүнээр шагнаж, “Дизайн сургалт-Хаврын гоёл-2025” уралдаанд ивээн тэтгэгчээр оролцох болсноо мэдэгдсэн юм. Түүнчлэн “Саксид” ХХК-аас Хувцас дизайны IV курсийн оюутан Э.Мөнхтулгыг “Faber-Castell” брэндийн зургийн иж бүрдлээр шагналаа.



"CITI СПОРТ"

СИТИ "АЯНГА" ХОЁР ХОЖИЛТОЙГООР ОЮУТНЫ ЛИГИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ БАЙНА



Сагсан бөмбөгийн Оюутны лиг үргэлжилсээр байна. СИТИ "Аянга" багийн тухайд эрэгтэй 1 дүгээр баг 2 хожил 2 хожигдолтой явж байгаа бол, эрэгтэй 2 дугаар баг 3 хожил 1 хожигдол, эмэгтэй баг 2 хожил 2 хожигдолтой явж байна. СИТИ "Аянга" баг Монголын Оюутны Универсиад Их наадмын мөнгөн медаль, Сүхбаатар дүүргийн Оюутны спортын IV наадмын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний алтан медаль, Сникерс лигийн алтан медаль, Монголын Оюутны лигийн түүхэнд анх удаа гурван жил дараалан аварга болсон бол 2024 онд мөн Оюутны лигийн аваргаар шалгарч, СИТИ "Аянга" баг Оюутны лигийн дөрвөн удаагийн аварга болсон юм. СИТИ "Аянга" баг анх 2014 онд байгуулагдсан бөгөөд Монголын оюутны сагсан бөмбөгийн спортын нүүр царай болсон шилдэг багуудын нэг юм. СИТИ "Аянга" баг нь эрэгтэй I, II баг болон эмэгтэй багийн 50 орчим тамирчидтай. СИТИ "Аянга" багийн ахлах дасгалжуулагчаар Хасын хүлэгүүд багийн тоглогч, Олон улсын хэмжээний мастер Д.Мөнхтүвшин, туслах дасгалжуулагчаар С.Эрхбаяр нар ажиллаж байна.



СИТИ "АЯНГА" БАГИЙН 2024.12.06-12,15-НЫ ӨДРҮҮДИЙН ТОГЛОЛТЫН ХУВААРЬ

2024.12.06. БААСАН ШУТИС СПОРТ ЗААЛ
18:00 ШУТИС ШАРКС ЭМ VS СИТИ ИС АЯНГА ЭМ
19:30 ШУТИС ШАРКС 1 VS СИТИ ИС АЯНГА

2024.12.15 МУИС СПОРТ ЗААЛ
14:00 СИТИ ИС АЯНГА 2 VS ГЛОБАЛ УДИРДАГЧ ИС
15:30 СИТИ ИС АЯНГА ЭМ VS ИЗОУИС EAGLES ЭМ

2024.12.09 ДАВАА ДХИС СПОРТ ЗААЛ
17:30 ДХИС ГЕНЕРАЛУУД VS СИТИ ИС АЯНГА

СИТИ "АЯНГА" ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ БАГ БАЙГУУЛАГДЛАА



"СИТИ" Их сургууль СИТИ "АЯНГА" волейболын шигшээ багаа байгууллаа. Оюутнуудын дунд өрсөлдөөнтэй, үе шаттайгаар шалгаруулалт явуулан багаа бүрдүүлээ. СИТИ "АЯНГА" волейболын шигшээ баг эрэгтэй 14, эмэгтэй 14 тамирчнаас бүрдэж байна. ийнхүү шигшээ багт орсон оюутнууд цаашид сургуулиа төлөөлөн тэмцээнд оролцох юм. СИТИ "АЯНГА" волейболын шигшээ

багийн тамирчид Н.Өсөхбаяр волейболын III зэрэгтэй, Б.Хосбаяр волейболын I зэрэгтэй, нийслэлийн аваргын хүрэл медаль, Хасумега стар багийн U17 багт тоглодог байсан, Д.Отгонпүрэв волейболын I зэрэгтэй, U14 шигшээ багийн улсын аваргын мөнгөн медаль, Завхан аймгийн аймгийн аварга шалгаруулах волейболын 3 алтан медальтай. Б.Батзориг хөнгөн атлетийн II дугаар зэрэгтэй,



С.Чинболд волейболын I зэрэгтэй, А.Чингүүн волейболын II зэрэгтэй, Баянгол дүүргийн алтан медальтай, Б.Батхүү хөнгөн атлетийн 100 метрийн төрөлд аймгийн 8 удаагийн аварга, улсын нэг удаагийн аварга, Азийн наадмын шилдэг 10-ийн 1, Г.Цэлмүүн волейболын өсвөрийн улсын аваргад 2 жил мөнгөн медаль, U17 сагсан бөмбөгөөр алтан медаль, Э.Төгөлдөр волейболын I зэрэгтэй, сагсан

бөмбөгийн I зэрэгтэй, Хэнтий аймагт зохион байгуулагдсан волейболын тэмцээнд алтан медаль, насанд хүрэгчдийн волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 жил дараалан хүрэл медаль, Өмнөговь аймагт зохион байгуулагдсан бүх ард түмний спартакиадад хүрэл медаль, клубуудын волейболын тэмцээнд мөнгөн медаль тус тус хүртсэн шилдэг оюутнуудаас бүрдэж байна.



СИТИ ИХ СУРГУУЛЬ

Мэдлэг бол Хүч, Эрх чөлөө - *Scientia est Potentia, Libertas*



ӨВЛИЙН ЭЛСЭЭЛТ

ЭХЭЛЛЭЭ



БАКАЛАВР



МАГИСТР



ДОКТОР

БҮРТГЭЛ:
2024.12.02 - 2025.02.05

Сургалтын бодлого,
зохицуулалтын газар:
8908-8833

Ахисан шатны сургууль:
7744-2244, 8908-9779

Цахим сургууль:
8908-8822



EMMA хөтөлбөрийн
Монгол дахь түнш
байгууллага





БАКАЛАВР



МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ,
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ,
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА АГСАН
**ДАШДОРЖИЙН ДЭМБЭРЭЛЦЭРЭНГИЙН
НЭРЭМЖИТ**

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

- Эрхзүй



ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ

- Сэтгүүл зүй
- Сэтгэл судлал
- Багш, гадаад хэлний боловсрол
- Багш, сургуулийн өмнөх боловсрол
- Багш, бага боловсрол
- Гадаад хэлний орчуулга



УРЛАГИЙН СУРГУУЛЬ

- Хөгжмийн урлаг
- Дуулах урлаг
- Жүжиглэх урлаг
- Найруулах урлаг
- Бүжгийн урлаг
- Багш, хөгжмийн боловсрол
- Багш, бүжгийн боловсрол

8908-8833



МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРҮҮД

- Эрх зүй
- Боловсрол судлал
- Бизнесийн удирдлага
- Соёл судлал
- Хувцасны дизайн
- Дуулах урлаг
- Урлаг судлал
- Гоо заслын урлаг, технологи
- Сэтгүүлзүй
- Аялал жуулчлал
- Зочлох үйлчилгээ
- Хот, бүс нутгийн менежмент



ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРҮҮД

- Урлаг судлал
- Бизнесийн удирдлага
- Менежмент
- Соёл судлал



БАКАЛАВР



БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

- Маркетинг
- Менежмент
- Нягтлан бодох бүртгэл
- Худалдаа
- Аялал жуулчлал
- Зочлох үйлчилгээ
- Агаарын тээврийн үйлчилгээ /онгоцны үйлчлэгч/



АРХИТЕКТУР-ДИЗАЙНЫ СУРГУУЛЬ

- Архитектур
- Интерьер дизайн
- Барилгын инженерчлэл
- График дизайн
- Програм хангамж
- Хувцасны дизайн



ГОО САЙХНЫ УХААНЫ СУРГУУЛЬ

- Арьс гоо засал+/make up, nail art/
- Үсчин стилист+/make-up, nail art/
- Сувилахуй

- Химийн технологи / Гоо сайхны бүтээгдэхүүн судлал